

ШИНЭЖИНСТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН “ХУУЛИА ДЭЭДЭЛЬЕ” БОЛЗОЛТ УРАЛДААНЫ ТАЙЛАН

2024 оны 12 дугаар сарын 09

Залаа

Аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль эрх зүйн хэлтсээс зохион байгуулж буй “Хуулиа дээдэлье” болзолт уралдаанд удирдамжийн дагуу төлөвлөгөө боловсруулан, хэрэгжүүлж ажиллаа. Аяны хүрээнд тус сумын Засаг даргын Тамгын газар нь 2024 онд сумын хэмжээнд гэмт хэрэг зөрчлийг бууруулах, урьдчилан сэргийлэх, аймгийн ИТХ, Засаг дарга болон бусад дээд шатны байгууллагын шийдвэрийн хэрэгжилтийг хангах, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, эрх зүйн ажлын үр дүнг сайжруулах, төрийн албан хаагчдийн сахилга батыг сайжруулахаар зорилт тавин дараах ажил, арга хэмжээг зохион байгууллаа. Үүнд:

Нэг. Эрх зүйн ажлын талаар

1.1. Сумын эрх зүйн ажлын чиглэлээр:

1.1.1. Засаг даргын захирамжийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 04 дүгээр сарын 20-ны өдрийн хүртэлх А01-А44, Б01-03 нийт 47 захирамжийг хянуулан Зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 10 дугаар сарын 28-нд аймгийн Засаг даргын тамгын газраас ирсэн ажлын хэсгийн гишүүн Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн Б.Анухатанд 98 Захирамжийг хянуулан ажилласан мөн 2024 оны жилийн эцсийн Захирамжийг хянуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

1.1.2. Жилийн эцсийн байдлаар Хууль эрх зүйн хэлтсээс 1 зөвлөмж, 46 албан бичиг ирснээс 18 хариутай албан бичгийн хариуг хугацаанд нь хүргүүлж зөвлөмж, чиглэлийн дагуу төлөвлөгөө гарган ажил, арга хэмжээ зохион байгуулан үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажилласан. 2 албан бичиг судлагдах шатанд явж байна. (Холбогдох зураг хавсралтаар Зураг.1.1)

1.1.3. Төсөвт байгууллагуудын дарга, эрхлэгч, захирал, нягтлан бодогчид, санхүүгийн албаны дарга, төсөв төрийн сангийн мэргэжилтэн зэрэг 12 албан тушаалтны 2023 оны ХАСХОМ-ийн өөрчлөлтийг 2024 оны 02 дугаар сарын 13-ны дотор, мөн Тусгай сан, соёлын байгууллага хариуцсан нягтлан бодогчын ХАСХОМ-ийг баталгаажуулж ажиллалаа.

1.1.4. Аймгийн авлигын эсрэг үйл ажиллагааны 2024 оны төлөвлөгөөний дагуу 04 сарын 01-ний өдрөөс эхлэн сумын авлигын эсрэг үйл ажиллагааны 2024 оны төлөвлөгөөг гарган батлуулж ажилласан. Гэмт хэрэг зөрчлөөс ангид байх хүрээнд цагдаагийн ахлах ахлагч Д.Балжинням Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын талаарх сургалтыг 04 дүгээр сарын 14-ний өдөр Мэдээллийн цагаар

иргэд, төрийн албан хаагчид орсон. 10 сарын 28-нд аймгийн Засаг даргын тамгын газраас ирсэн ажлын хэсгийн гишүүн Цагдаа Оргилболд Гэмт хэрэг зөрчлийн талаар, гэр бүлийн хүчирхийллийн талаар тус тус албан хаагч, ард иргэд, ААН эрхлэгч нар нийт 98 иргэдэд сургалт орлоо. Албан хаагч нараас авлигын гэмт хэрэгт холбогдсон тохиолдол бүртгэгдээгүй байна.

(Холбогдох зураг хавсралтаар Зураг.1.2)

1.1.5.Эрх зүйн ажлын мэдээг хагас жилээр болон жилийн эцсээр хугацаанд хүргүүлэн ажиллаж байна.

1.1.6.Ерөнхий боловсролын сургуулийн захирлын А/01-А/15, Б/01-Б/25 тушаал, Цэцэрлэгийн эрхлэгчийн А/01-А/11, Б/01-Б/08, Соёлын төвийн даргын А/01-А/04 тушаал, зэрэг 1-2 дугаар улиралд гаргасан нийт 63 тушаалын хуулийн үндэслэл, заалт, найруулга зүй, үг, үсгийн алдааг хянан шалгаж зөвлөгөө өгч ажилласан.

1.1.7. Хууль эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтний сул орон тоонд төрийн албаны ерөнхий шалгалтад тэнцэж нөөцөд бүртгэгдсэн иргэдээс сонгон Г.Батчимэгийг 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн томилон ажиллуулж байна. Мэргэжилтэн Г.Батчимэг нь:

- Төрийн албаны зөвлөлийн 7:4:10 сургалтад Пүрэв гараг бүр
- Цахим үйлчилгээний операторыг дадлагажуулах сургалт
- “Эрх зүйн хөтөч”-ийг чадавхжуулах сургалт зэрэг сургалтад хамрагдаж ажлын байран дээрээ мэдлэг чадвараа бататган үр дүнтэй ажиллаж байсан бөгөөд 2024 оны 06 сараас үүрэгт ажлаасаа чөлөөлөгдөн орон тооны албан хаагч Ц.Наранцэцэг албан үүргээ гүйцэтгэн ажиллаж байна.

1.1.8.Сумын Засаг даргын захирамж, Тамгын газрын даргын тушаалыг “Захиргааны ерөнхий хууль”-ийн дагуу хувийн хэрэг хөтөлж захиргааны актын төсөл, санал авсан тухай хяналтын хуудсыг дагалдуулан баримтжуулсны дараа хэвлэмэл хуудсан дээр албажуулж хэвшсэн. Мөн Засаг даргын 98 захирамжийг хянуулан ажилласан байна. 2024 оны нийт Захирамжийг 12 сарын 16-нд хянуулахаар бэлтгэл ажлыг хангаж ажиллаж байна

1.1.9.Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн талаарх сургалтад онлайнаар согтууруулах ундааны тусгай зөвшөөрөлтэй 16 аж ахуй нэгжүүдийг хамруулсан мөн 10 дугаар сарын 28-нд аймгийн Хэрэглэгчийн эрхийг хамгаалах нийгэмлэгийн дарга Балдангомбо нийт аж ахуй нэгжүүдийн дарга нарт сургалт мэдээллийг өгч ажилласан бөгөөд аймгийн Хэрэглэгчийн эрхийг хамгаалах нийгэмлэгийн мэргэжилтэн Б.Анухатан, Хүнс,

ХЗБХ-и, Монгол улс
эрх зүйн үйлчилгээний оператор

жижиг, дунд үйлдвэрлэл, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн Ж.Одонжаргал, Хууль, эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн Ц.Наранцэцэг зэрэг 5 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг аймгийн ажлын хэсэгтэй хамтран Дэлгүүрүүдээр явж хяналт шалгалт хийж ажилласан байна. Зөрчлийн тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Зөвшөөрлийн тухай хуулийн талаарх сургалтыг цагдаагийн ахлах ахлагч Д.Балжинням 04 дүгээр сарын 14-ний өдөр мөн 11 сарын 25-нд Цагдаагийн ахмад Алтангэрэл Мэдээллийн цагаар иргэд, төрийн албан хаагчид орсон. Аймгийн шүүхийн тамгын газартай хамтран ажиллаж Шүүхийн иргэдийн төлөөлөгчдийн эрх зүйн байдлын талаар сургалт хийгдэж нийт 8 иргэнийг танхимаар, 2 иргэнийг онлайнаар хамрагдуулсан. (Холбогдох зураг хавсралтаар Зураг.1.3)

1.1.10.Хуулиа дээдэлье болон чадварлаг эрх зүйн хөтөчийн ажлын төлөвлөгөө, гүйцэтгэлийн төлөвлөгөөг тус тус гарган холбогдох ажлуудыг хийж гүйцэтгэж байна. Мөн сургалтын төлөвлөгөөг сар бүр гарган батлуулж ажиллалаа. Жилийн эцсийн байдлаар салбарын хэмжээнд хэрэгжиж байгаа хууль тогтоомжийн хүрээнд 10 сургалт, 1 АХА тэмцээн, 1 нээлттэй өдөрлөг (эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөрт зориулж зохион байгуулсан ажлын үеэр нэг цэгийн үйлчилгээг ажиллуулж, иргэдэд зөвлөгөө мэдээлэл өгсөн) зохион байгуулж ажилласан байна. (Холбогдох зураг хавсралтаар Зураг.1.4)

1.2.Байгууллагын хууль эрх зүйн ажлын чиглэлээр:

1.2.1.Байгууллагын хүрээнд эрх зүйн ажлыг сайжруулах чиглэлээр Байгууллагын мэдээллийн цагийг 7 хоног бүрийн Мягмар гарагт зохион байгуулж ажиллалаа. Сургалтын хуваарийг сар бүр албан хаагч нараас саналыг авч, сургалтын төлөвлөгөөг батлуулж ажилласан. Мэдээллийн цагаар гаднаас 5 удаа багш, лекторыг (1."Хүүхдийн эрх" Аймгийн Боловсрол шинжлэх ухааны газрын багтай хамтран 4-р сургуулийн сэтгэл зүйч П.Сэнгэмаа, 2.Аймгийн Хүүхэд гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын дарга Мэндбаяр "Гэр бүлийн хөгжлийг дэмжих жил"-ийн нээлтийн үйл ажиллагааг хийж, Хүүхэд хамгааллын шинэчилсэн хуулийг олон нийтэд сурталчлах сургалт орж, мөн Аймгийн Өсвөр үе охидын эмч Т.Одонтунгалаа 8-9-р ангийн сурагчдад өсвөр үеийн эрүүл мэндийн сургалт, 3.Монголын үг урлаачдын нийгэмлэгийн тэргүүн, хүмүүнлэгийн сэтгэл судлаач, доктор, Лектор Чила буюу Г.Бандицэрэн 2024 оны 05 дугаар сарын 13-ны өдөр ЕБС-ийн сурагчдад "Сурч боловсрохын ач холбогдол, үе тэнгийн дээрэлхэлт", Төрийн албан хаагч, иргэд, эцэг эхчүүдэд "Хүний хөгжил, амьдралын үнэ цэнэ, гэр бүлийн сэтгэл зүй" 2024 оны 11 дүгээр сарын 19-нд Гэр бүл судлаач, сэтгэл зүйч

Г.Наранбаатар “Гэр бүлийн үнэ цэнэ, аз жаргал, харилцаа хандлага”, “Хамт олны уур амьсгал, багийн ажиллагаа, байгууллагын соёл” сэдвээр тус тус сургалт) урин иргэд, төрийн албан хаагчдад сургалт, зөвлөгөө мэдээлэл өгч, мөн аймгийн Засаг даргын тамгын газраас 10 дугаар сарын 28-нд Зөвлөн туслах, хяналт шалгалт хийх ажлын хэсэг 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр ирж Сумын ард, иргэд, төрийн албан хаагчид, аж ахуй нэгжийн дарга нарт нийт 98 иргэдэд, дотооддоо нийт 13 удаагийн сургалтыг орсон байна (Холбогдох зураг хавсралтаар Зураг.1.2.1)

1.2.2.Жилийн эцсийн байдлаар нийт байдлаар Хууль эрх зүйн хэлтсээс 4 зөвлөмж, 35 албан бичиг ирснээс 35 хариутай албан бичгийн хариуг хугацаанд нь хүргүүлж зөвлөмж, чиглэлийн дагуу төлөвлөгөө гарган ажил, арга хэмжээ зохион байгуулан үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажилласан.

1.2.3.Аймгийн авлигын эсрэг үйл ажиллагааны 2024 оны төлөвлөгөөний дагуу 04 сарын 01-ний өдрөөс эхлэн сумын авлигын эсрэг үйл ажиллагааны 2024 оны оны төлөвлөгөөг гарган батлуулж ажилласан. Мөн гэмт хэрг зөрчлөөс ангид байх хүрээнд цагдаагийн ахлах ахлагч Д.Балжинням Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын талаарх сургалтыг 04 дүгээр сарын 14-ний өдөр 11 дүгээр сарын 26-ны өдөр Цагдаагийн тасгийн хурандаа Алтангэрэл Мэдээллийн цагаар иргэд, төрийн албан хаагчид орсон. Албан хаагч нараас авлигын гэмт хэрэгт холбогдсон тохиолдол бүртгэгдээгүй байна. Мөн 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдөр томилогдсон Төрийн үйлчилгээний ажилтан, 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс томилогдсон Нийгмийн бодлогын мэргэжилтэн Ш.Даваацэрэн нарыг Хууль эрх зүйн хэлтсээс зохион байгуулсан 2024 оны 02 дугаар 21-ний өдрийн “Авлига ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх нь” сэдэвтэй сургалтад онлайнаар хамруулсан. (Холбогдох зураг хавсралтаар Зураг.1.3)

1.2.4.Хуулиа дээдэлье аяны төлөвлөгөөг боловсруулан батлуулж, тайлан биелэлтийг хугацаанд нь 05 дугаар сарын 22-ны өдөр хүргүүллээ. ✓

1.2.5. “Эрх зүйн хөтөч”-ийг чадавхжуулах 03 дугаар сарын 26, 27-ны өдрүүдэд зохион байгуулагдсан сургалтад хамруулж, 2 өдрийн цалинтай чөлөө болон томилолтын зардлыг Тамгын газраас олгож ажилласан. Мөн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан хагас бүтэн жилээр дүгнүүлэхээр ажиллаж байна.

1.2.6.Сумын Засаг даргын захирамж, Тамгын газрын даргын тушаалыг “Захиргааны ерөнхий хууль”-ийн дагуу хувийн хэрэг хөтөлж захиргааны актын төсөл, санал авсан тухай хяналтын хуудсыг дагалдуулан баримтжуулсны дараа хэвлэмэл хуудсан дээр албажуулж хэвшсэн. Мөн Засаг даргын 47 захирамжийг хагас жилээр хянуулан Хууль эрх зүйн хэлтэстээс ирүүлсэн зөвлөмжийг

хэрэгжүүлэн ажилласан бөгөөд 10 дугаар сард аймгийн ЗДТГ-аас ирсэн хяналт шалгалтын гишүүн Б.Анухатанд 98 Захирамжийг хянуулсан, жилийн эцсийн Захирамжуудыг 2025 оны 01 сарын эхээр хянуулахаар бэтгэл ажлыг ханган ажиллаж байна.

1.2.7.Хуулиа дээдэлье болон чадварлаг эрх зүйн хөтөчийн ажлын төлөвлөгөө, сумын 2024 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг байгууллагын дарга эрхлэгч нар, албан хаагч нарт танилцуулж хамтарч ажиллах талаар санал тавьж ажиллалаа. Үүний хүрээнд хууль тогтоомж сурталчлах байгууллагын /ЗДТГ/ сургалтын төлөвлөгөөг сар бүр гарган батлуулж, долоо хоног бүрийн Мягмар гарагт сургалтыг сарын хуваарийн дагуу орж ажиллалаа. Мөн ЕБСургууль 04 сарын 01-ний өдрөөс эхлэн 12 дугаар сарын 02-ны өдрийг хүртэлх хугацаанд долоо хоног бүрийн Лхагва эсвэл Баасан гарагт 17:00 цагаас Хууль эрх зүйн сургалтыг дотооддоо зохион байгуулж байна. Үүнтэй холбогдуулан 04 дүгээр сарын 12-ны өдөр ЕБСургуулийн 29 багш, ажилтан нарт "Эрх зүйн цахим цахим сайтын танилцуулга"-ын талаар сургалт орсон. Жилийн эцсийн байдлаар салбарын хэмжээнд хэрэгжиж байгаа хууль тогтоомжийн хүрээнд 10 сургалт, 1 АХА тэмцээн, 1 нээлттэй өдөрлөг (эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөрт зориулж зохион байгуулсан ажлын үеэр нэг цэгийн үйлчилгээг ажиллуулж, иргэдэд зөвлөгөө мэдээлэл өгсөн) зохион байгуулж ажилласан байна.

(Холбогдох зураг хавсралтаар Зураг.1.2.2)

Хоёр. Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд

2.1.Сумын хэмжээнд гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр:

2.1.1.Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн талаарх сургалтад согтууруулах ундааны тусгай зөвшөөрөлтэй 16 аж ахуй нэгжийг хамруулсан. Мөн Зөрчлийн тухай хууль, Зөвшөөрлийн тухай хуулийн талаарх сургалтыг цагдаагийн ахлах ахлагч Д.Балжинням 04 дүгээр сарын 14-ний өдөр Мэдээллийн цагаар иргэд, төрийн албан хаагчид орсон. Мөн жилийн эцсийн байдлаар сумын Цагдаагийн хэсгээс нийт 291 удаа эргүүлийн хяналт шалгалтыг хийсэн байна. Эргүүлийн үед ноцтой гарсан зөрчлийн тохиолдол гараагүй байна.

(Холбогдох зураг хавсралтаар Зураг.1.3)

2.1.2. 2024 онд ИТХ-аар хяналтын камерны сайжруулалтад 20 сая төгрөгийг төсөвлөж, 3 дугаар улирлаас төсөвт тохируулан камерны сайжруулалтыг хийхээр төлөвлөж ажиллаж байна.

2.1.3.Багийн иргэдийн нийтийн хурал он гарснаар тус бүр 3, 3, удаа зохион байгуулагдсан. Хурал бүр дээр Цагдаагийн хэсгээс Эрүүгийн болон зөрчлийн тухай

хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Зөвшөөрлийн тухай хуулийн талаарх сургалтыг 6 удаа зохион байгуулсан. Мөн жилийн эцсийн гэмт хэрэг гаралтын мэдээ тайланг танилцуулж, цаашид гэмт хэргээс хэрхэн ангид байх, залилангийн гэмт хэргийн хор уршгийн талаар иргэдэд мэдээлэл хийлээ. Мөн ЕБСургуулийн 6-9 ангийн сурагчдад үе тэнгийн дээрэлхэлт, электрон тамхины хор уршиг, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаарх сургалтыг 2 удаа зохион байгуулж, сурагчидтай чөлөөт ярилцлага хийсэн.

(Холбогдох зураг хавсралтаар Зураг.2.1)

2.1.4.Архины хамааралтай болсон 4 иргэнийг Аймагт албадан сургалтад хамрууллаа. 2 иргэн 7 хоногийн сургалтад хамрагдаж, 2 иргэн 14 хоногийн сургалтад хамрууллаа.

2.1.5.Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд замын хаалт, тэмдэг 16 ширхэгийг хийсэн. Мөн ЕБСургууль, сумын хамтарсан багтай хамтран сургуулийн хүүхдүүдэд зориулсан зурган тэмдэглэгээ хийлгэх ажлыг төлөвлөөд ИТ хуралд танилцуулаад, Дурсамж принт ХХК-д захиалгаа хүргүүлсэн байна.

2.1.6.Байгууллагын албан хаагчдыг гэмт хэрэг, зөрчилд холбогдохгүй байх хүрээнд Цагдаагийн хэсгээс Н.Баасанжаргал "Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх Тухай" хуулийн талаарх сургалтыг төрийн албан хаагчдад зохион байгуулсан. Мөн мэдээллийн цагаар гаднаас 4 удаа багш, лекторыг (1."Хүүхдийн эрх"-ийн талаарх сургалт, гэр бүлийн хүчирхийллийн эсрэг хүүхэдтэй хэрхэн харьцах талаарх сургалтыг Аймгийн Боловсрол шинжлэх ухааны газрын багтай хамтран 4-р сургуулийн сэтгэл зүйч П.Сэнгэмаатай хамтран зохион байгуулсан, 2.Монголын үг урлаачдын нийгэмлэгийн тэргүүн, хүмүүнлэгийн сэтгэл судлаач, доктор, Лектор Чила буюу Г.Бандицэрэн 2024 оны 05 дугаар сарын 13-ны өдөр ЕБС-ийн сурагчдад "Сурч боловсрохын ач холбогдол, үе тэнгийн дээрэлхэлт", Төрийн албан хаагч, иргэд, эцэг эхчүүдэд "Хүний хөгжил, амьдралын үнэ цэнэ, гэр бүлийн сэтгэл зүй, гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргээс хэрхэн ангид байх", Гэр бүл судлаач, сэтгэл зүйч Г.Наранбаатар 2024 оны 11 дүгээр сарын 19-нд "Гэр бүлийн үнэ цэн, аз жаргал, харилцаа хандлага", Хамт олны уур амьсгал, багийн ажиллагаа, байгууллагын соёл сэдвүүдээр тус тус сургалтыг хамтран зохион байгууллаа) урин иргэдэд, төрийн албан хаагчдад гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийн талаарх сургалтыг орсон.

(Холбогдох зураг хавсралтаар Зураг.1.2.2)

2.2.Байгууллагын хэмжээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр:

2.2.1. Байгууллагын албан хаагчдыг гэмт хэрэг, зөрчилд холбогдохгүй байх хүрээнд Цагдаагийн хэсгээс Н.Баасанжаргал “Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хуулийн талаарх сургалтыг төрийн албан хаагчдад зохион байгуулсан. (Холбогдох зураг хавсралтаар Зураг.2.1)

Гурав.Сум, байгууллагаас иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх ажлын хүрээнд

3.1. “Төрийн мэдээлэл” 2023 оны сэтгүүлийн архивлсан байна. 2024 оны “төрийн мэдээлэл” сэтгүүлийг захиалан өөрчлөлт хөдөлгөөнийг хийж ажиллаж байна.

3.2. Хуулиа дээдэлье болон чадварлаг эрх зүйн хөтчийн ажлын төлөвлөгөө, сумын 2024 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг байгууллагын дарга эрхлэгч нар, албан хаагч нарт танилцуулж, мөн хууль тогтоомжийн хүрээнд иргэдэд өөрсдийн албан тушаалын онцлогоос хамаарч зөвлөгөө мэдээлэл, хүргэж ажилласан бол бүртгэх бүртгэлийн маягтыг байгууллагын дарга, эрхлэгч, захирал болон албан хаагчдад файлаар өгч ажилласан.

Хөдөлмөр халамжийн мэргэжилтэн – 16

Нийгмийн бодлогын мэргэжилтэн – 13

Нийгмийн даатгалын улсын байцаагч – 23

Татварын улсын байцаагч – 14

Хууль эрх зүйн мэргэжилтэн – 10 тус тус үйлчилгээг үзүүлсэн. Нийт зөвлөгөө өгсөн иргэн -212

ЗДТГ-аас угтах үйлчилгээг 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 05 дугаар сарын 01-ний өдрийн хооронд зохион байгуулж ажилласан. Энэ үеэр угтах үйлчилгээний жижүүрүүдэд холбогдох албан тушаалтнууд гарын авлага, ном сонин, зөвлөмжүүдийг хэвлэн өгч иргэдэд таараалгаж ажилласан. Мөн ЕБСургууль 04 сарын 01-ний өдрөөс эхлэн долоо хоног бүрийн Лхагва эсвэл Баасан гарагт 17:00 цагаас Хууль эрх зүйн сургалтыг дотооддоо зохион байгуулж байна.

(Холбогдох зураг хавсралтаар Зураг.3.1)

3.3.Иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, зөвлөгөө тусламж өгөх зорилгоор Долоо хоног бүрийн Даваа гарагт иргэдийн “мэдээллийн цаг”-ийг 2024 оны 12 дугаар сарын 02-ний өдрийг хүртэл зохион байгуулсан. Мэдээллийн цагаар албан байгууллагын захирал, дарга, эрхлэгч болон төрийн албан хаагчид өөрсдийн ажил мэргэжлийн онцлогоос хамаарч шинэчлэгдсэн болон иргэдэд хэрэгтэй хууль

тогтоомж, зөвлөгөө мэдээллийг нийт **15 удаагийн сургалт, 1 АХА тэмцээн** (Үндсэн хууль батлагдсаны 100 жил, ардчилсан Үндсэн хууль батлагдсаны 32 жилийн ой болон Татварын тухай хуулийн талаар АХА тэмцээнийг Авто тээврийн үзлэгийн өдөр буюу 05 дугаар сарын 07-нд нийт 50 иргэдийн дунд зохион байгуулсан), **1 гар зургийн уралдаан** (Хүүхэд багачуудын татварын тухай мэдлэг, боловсролыг дээшлүүлэх зорилгоор ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд "Татвар хөгжлийн үндэс" сэдэвт гар зургийн уралдааныг зарлаж, нийт 16 хүүхэд бүтээл ирүүлснээс эхний 4 байрыг шалгаруулж өргөмжлөл, мөнгөн шагналаар урамшуулсан) **1 нээлттэй өдөрлөг** (эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөрт зориулж зохион байгуулсан ажлын үеэр нэг цэгийн үйлчилгээг ажиллуулж, иргэдэд зөвлөгөө мэдээлэл өгсөн) зохион байгуулж ажилласан байна.

Нийгмийн даатгалын тухай хууль, Эрүүгийн болон Зөрчлийн тухай хууль, Үндсэн хуулийн талаар нийт 200 ширхэг гарын авлага хийж, байгууллагын дарга нартай биечлэн уулзаж, хууль эрх зүйн чиглэлээр 2024 онд хийгдэх ажлуудын төлөвлөгөөг танилцуулж, хамтран ажиллах талаар уулзалт хийж 10 ширхэг гарын авлагыг тус тус тарааж өгсөн. 100 ширхэг гарын авлагыг Тээврийн үзлэгийн үеэр иргэдэд тарааж ажилласан. (Холбогдох зураг хавсралтаар Зураг.3.2)

3.4.Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөрт зориулан зохион байгуулсан нээлттэй өдөрлөг зохиогдсон. Өдөрлөгөөр илтгэлийн уралдаан, чуулган, спортын тэмцээн, нэг цэгийн үйлчилгээ зэрэг олон үйл ажиллагааг зохион байгуулсан. Нэг цэгийн үйлчилгээгээр Тамгын газрын албан хаагчид албан тушаалын онцлог бүрийн эрх зүйн зөвлөгөө мэдээллийг өгч ажиллалаа. Өдөрлөгийг сумын албан ёсны цахим хуудас болох Шинэжинст ЗДТГ фэйжээр лайв хэлбэрээр давхар зохион байгуулж ажилласан. (Холбогдох зураг хавсралтаар Зураг 1.4)

ХЯНАСАН
ЗАСАГ ДАРГА



Л.БАТХУЯГ

БИЕЛЭЛТ ГАРГАСАН
ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН Ц.НАРАНЦЭЦЭГ

гаргахгүй байх талаар зөвлөгөө, мэдээлэл өгч хадгалалтын хугацаа дууссан, хаяг шошгын зөрчилтэй 8 нэр төрлийн 1.065.950 төгрөгийн бүтээгдэхүүнийг сумын Засаг даргын 2024 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн А/100 дугаар захирамжаар томилогдсон ажлын хэсэгт хүлээлгэн өгч газар дээр нь устгуулж зөрчлийг арилгуулж ажилласан байна. Тус шалгалтад 18 аж ахуй нэгж хамрагдсан бөгөөд ганцаарчилсан зөвлөгөө авсан байна



Зураг.1.3

Үндсэн хууль батлагдсаны 100 жил, ардчилсан Үндсэн хууль батлагдсаны 32 жилийн ой болон Татварын тухай хуулийн талаар АХА тэмцээнийг зохион байгуулж, гарын авлага тараалаа. Эмэгтэйчүүдийн баярыг тохиолдуулан нээлттэй өдөрлөг зохион байгуулаа.





Зураг 1.4

Байгууллагын мэдээллийн цагаар гаднаас 3 удаа багш, лекторыг урин иргэд, төрийн албан хаагчдад сургалт, зөвлөгөө мэдээлэл өгч, мөн дотооддоо нийт 10 удаагийн сургалтыг орсон бай



Зураг 1.2.1

ЕБСургуулийн 29 багш, ажилтан нарт “Эрх зүйн цахим цахим сайтын танилцуулга”-ын 04 дүгээр сарын 12-ны өдөр талаар сургалт орсон.



Зураг. 1.2.2

Цагдаагийн хэсгээс Эрүүгийн болон зөрчлийн тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Зөвшөөрлийн тухай хуулийн талаарх сургалтыг 3 удаа зохион байгуулсан. ЕБСургуулийн 6-9 ангийн сурагчдад үе тэнгийн дээрэлхэлт, электрон тамхины хор уршиг, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаарх сургалтыг 2 удаа зохион байгуулж, сурагчидтай чөлөөт ярилцлага хийсэн.



ЗДТГ-аас угтах үйлчилгээг 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 05 дугаар сарын 01-ний өдрийн хооронд зохион байгуулж ажилласан. Энэ үеэр угтах үйлчилгээний жижүүрүүдэд холбогдох албан тушаалтнууд гарын авлага, ном сонин, зөвлөмжүүдийг хэвлэн өгч иргэдэд таараалгаж ажилласан.



Зураг 3.1

Иргэдийн мэдээллийн цагийг долоо хоногийн Даваа гараг бүр 15 удаагийн сургалт, 1 АХА тэмцээн, 1 гар зургийн уралдаан, 1 нээлттэй өдөрлөгийг зохион байгуулсан байна. Мөн холбогдох гарын авлага, брошур, зөвлөгөө мэдээллийг өгч ажилласан





Зураг.3.2